

ШИНЭ, ЯЛГААТАЙ, ЖИГДЭРСЭН, ТОГТВОРЖСОН БОЛОХЫГ ТОГТООХТОЙ ХОЛБОГДСОН ЖУРАМ

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү журмын зорилго нь таримал ургамлын үр, сортын тухай хуулийн дагуу сортын бүтээгчийн эрхийн хүсэлт гаргасан сортыг шинэ, ялгаатай, жигдэрсэн, тогтворжсон болохыг тогтоох үйл ажиллагааг зохицуулахад оршино.

Нэр томъёоны тодорхойлолт

Туршилтын удирдамж /test guideline /- тодорхой таримал ургамлын зүйл, бүлэг сортын хувьд шинэ сортыг шалгахад зориулж хүрээлэнгээс тусгайлан баталж, нийтэд мэдээлсэн баримт бичгийг;

Техникийн асуулт /technical Questionare/-

ХОЁР. ЯЛГААТАЙ, ЖИГДЭРСЭН, ТОГТВОРЖСОН БОЛОХЫГ ТОГТООХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хүсэлт гаргасан сортын ялгаатай, жигдэрсэн, тогтворжсон болохыг тогтоох үйл ажиллагаа нь хээрийн туршилт болон лаборторийн шинжилгээнээс бүрдэх бөгөөд Ургамлын шинэ сортыг хамгаалах олон улсын конвенцийн шаардлагад нийцүүлэн туршилтын удирдамжийн дагуу тогтооно.

Сортын ялгаатай, жигдэрсэн, тогтворжсон болохыг тогтоох үйл ажиллагааг Ургамал, газар тариалангийн хүрээлэн /цаашид хүрээлэн гэх/ гүйцэтгэнэ.

Ургамлын шинэ сортыг хамгаалах олон улсын холбооны гишүүн улс орны хамтран ажиллах гэрээний үндсэн дээр шинэ сортын ялгаатай, жигдэрсэн, тогтворжсон болохыг тогтоох үйл ажиллагааг дараах тохиолдолд гадны хүрээлэнгээр гүйцэтгүүлж болно. Үүнд:

1. Тухайн улсын сортын хамгааллын байгууллагаас шинэ сортын хамгаалал авсан.
2. Шинэ сортын ялгаатай, жигдэрсэн, тогтворжсон болохыг тогтоох үйл ажиллагааг тухайн хүрээлэн өмнө нь тодорхойлж байсан,
3. Тухайн улсын агро-экологийн нөхцөл нь Монгол улстай төстэй, харьцуулж болохоор бол.

Энэ тохиолдолд хүрээлэн гадны хүрээлэнд тухайн хүсэлт гаргасан сортын техникийн асуултын хуулбар болон шинэ сортын хамгаалал авахаар ирүүлсэн хүсэлтийн хамт явуулна.

Өмнө нь шинэ сортын ялгаатай, жигдэрсэн, тогтворжсон болохыг тогтоох үйл ажиллагааг хийж байсан туршлагагүй, үндэсний туршилтын удирдамж байхгүй хүрээлэн өөрийн гэсэн туршилтын удирдамжийг шинээр хөгжүүлж, энэ талаар Ургамлын шинэ сортыг хамгаалах олон улсын холбоонд мэдээлнэ.

Шинэ сортын бүтээгчийн эрхийн хүсэлт гаргагч уг сортыг шалгахад шаардлагатай үржүүлгийн материалыг хүрээлэнд өгнө.

Шинэ сортын хамгааллын давуу эрхийг нэхэмжилсэн, анхны хүсэлт цуцлагдсан, татгалзсан тохиолдолд шалгахад шаардагдах үржүүлгийн материалыг хөдөө аж ахуйн таримал ургамлын хувьд 6 сарын дотор, модлог ургамлын хувьд 1 жилийн дотор хүргүүлсэн байна. Энэ хугацаа нь тухайн улсад анхны хүсэлт цуцлагдсан болон татгалзсан өдрөөс эхэлж тоологдоно.

Хүрээлэн үржүүлгийн материалын тоо, хэмжээ, чанар, хэзээ, хаана хүлээж авахыг хүсэлт гаргагчид мэдэгдэнэ.

Үржүүлгийн материал нь эрүүл, өвчин, хортонд нэрвэгдээгүй, ямар нэгэн боловсруулалтад ороогүй байх шаардлагатай.

Шинэ сортын ялгаатай, жигдэрсэн, тогтворжсон болохыг тогтоох үйл ажиллагаа нь хээрийн туршилт болон лабораторийн шинжилгээнээс бүрдэнэ.

Туршилтын хамгийн бага үргэлжлэх хугацаа нь 2 жил байна. Шинэ сортын ялгаатай байдлыг илүү тодорхой шийдвэрлэх зорилгоор уг хугацааг 3 жил хүртэл сунгаж болно.

Хээрийн туршилтыг нэг байршилд явуулна. Шинэ сортын чухал шинж тэмдэг уг газарт илрэхгүй тохиолдолд өөр байршлыг сонгож болно.

Хээрийн туршилтыг явуулахдаа шинээр хүсэлт гаргасан сортыг лавлах цуглуулгад байгаа хяналтын сортуудтай харьцуулах замаар сортын ялгаатай байдлыг тодорхойлно.

Лавлах цуглуулгад дараах сортууд байна. Үүнд:

1. Монгол Улсын сортууд
2. Ижил төстэй географикийн бүсийн сортууд
3. Хүсэлт гаргагчийн санал болгосон сортууд
4. Эрлийз сортын эцэг, эх сортууд---
5. Бусад шалгах сортууд
6. Ургамлын шинэ сортыг хамгаалах олон улсын холбооны жишээ сортууд

Шинэ сортыг шинж тэмдгээр нь тодорхойлох бөгөөд эдгээр шинж тэмдэг нь ялгаатай, жигдэрсэн, тогтворжсон болохыг тогтоох үйл явцаар шалгагдана. Сортын эдийн засгийн ач холбогдлыг үл харгалзан шинэ сортын ялгаатай, жигдэрсэн, тогтворжсон болохыг тогтооно.

Туршилтын эхний жилийн үр дүнгээр ялгаатай, жигдэрсэн, тогтворжсон байдлын урьдчилсан тайлан гарна. Уг тайлан нь хээрийн туршилтын явцад илэрсэн асуудлыг багтаасан ялгаатай, жигдэрсэн, тогтворжсон байдлыг шалгах үйл явцын үр дүнгийн мэдээллийг агуулсан байна. Урьдчилсан тайлангийн загвар нь энэ журмын салшгүй хэсэг байна.

Туршилтын төгсгөлд эцсийн тайланг ургамлын шинэ сортыг хамгаалах олон улсын холбооны шаардлагад нийцүүлэн боловсруулна. Уг тайлан эерэг гарсан тохиолдолд сортын тодорхойлолтыг хавсаргана. Тайлангийн загвар нь энэ журмын салшгүй хэсэг байна.

Хэрвээ шалгагч нь хүрээлэн биш өөр хэн нэгэн хийж байгаа нөхцөлд ялгаатай, жигдэрсэн, тогтворжсон байдлыг тогтоосон тайлан, сортын тодорхойлолтыг хамгийн боломжит хурдан хугацаанд хүрээлэнд хүргүүлнэ.

**ГУРАВ. СОРТЫН ШИНЭ, ЯЛГААТАЙ, ЖИГДЭРСЭН,
ТОГТВОРЖСОН БОЛОХЫГ ТОГТООХ АРГА**

Ажиглалтын арга хэмжиж тодорхойлох(М), харж тодорхойлох (V) аргуудаас бүрдэнэ.

Ажиглалтын арга	Тайлбар
Хэмжиж тодорхойлох (М)	Урт, өргөнийг хэмжих, жинлэх, тоолох гэх мэт
Харж тодорхойлох (V)	Үнэр, амт, барьж тэмтрэх гэх мэт

Сортын шинж чанарт хүрээлэн буй орчны нөлөөлөл байж болох бөгөөд тоон болон чанарын шинж чанарын генетикийн болзошгүй байдлыг илэрхийлнэ. Хүрээлэн буй орчны ямар нөлөөлөл хамгийн бага нөлөөлдгийг тодорхойлсон байна.

Тухайн төрөл зүйлийн ургамлын болон ургамлын бүлгийн шинж чанарын жагсаалт бүхий туршилтын удирдамжийг Ургамлын шинэ сортыг хамгаалах олон улсын холбооны шаардлагад нийцүүлэн хүрээлэн боловсруулж, нийтэд мэдээлнэ.

Туршилтын удирдамжид заавал болон нэмэлтээр шалгах шинж чанарын жагсаалт байна. Дээр дурдсан туршилтын удирдамж байхгүй тохиолдолд хүсэлт гаргагчийн тодорхойлсон сортын шинж чанарыг харгалзан үзэж болно. Энэ тохиолдолд хүрээлэн аль шинж чанараар үнэлгээ хийхээ шийднэ.

Сортын үзүүлэлтийг тоон болон чанарын гэж ангилна.

Сортын чанарын үзүүлэлтийг шинж чанарыг илэрхийлэх хэлбэр, нөхцөл байдлын үнэлгээнд үндэслэн тогтооно. Шинж чанарыг илэрхийлэх хэлбэр нь тогтмол бус, тасалдсан шинж чанартай байна. Нөхцөл байдлыг үнэлэх, шинж чанарын илэрхийлэх хэлбэрийг үе шатаас нь хамаарч тодорхойлно. Энэ үе шатаар хязгаарлагдахгүй бөгөөд тухайн шинж чанарын илэрхийлэгдэх хэлбэрийн үе шатыг стандарт болон ижил сорттой харьцуулах замаар тодорхойлно.

Сортын тоон шинж чанар нь хэмжиж болохуйц, нэгээс нөгөө хүртэл тасралтгүй нэг хувьсагчаар илэрхийлнэ. Тоогоор илэрхийлнэ. Хэрвээ тоон шинж чанарын хэмжилт ялангуяа амт, үнэр зэрэг мэдрэхгүйн шинж чанартай тодорхойлоход хэцүү бол сортын чанарын үнэлгээг хийх замаар тодорхойлж болно.

Сортын чанарын болон тоон шинж чанарыг илэрхийлэх хэлбэрийн үе шатыг зургаар баримтжуулна.

Шинж чанар бүрийг тусад нь тодорхойлно.Тоон зарим шинж чанаруудыг тухайлбал, урт, өргөн гэх мэтийг хамтад нь тодорхойлж болно.

Хоёр сортыг дараах тохиолдолд ялгаатай гэж үзнэ. Үүнд.

- ялгаа нь хамгийн багадаа нэг туршилтын талбайд тодорхойлогдсон
- тодорхой
- тогтмол

Чанарын шинж чанарын хувьд хоёр сортын хоорондын ялгаа хэрвээ шинж чанарыг илэрхийлэх хэлбэрийн хувьд хоёр өөр үе шатанд байсан тохиолдолд тодорхой байх ёстой. Сортын хоорондын ямарваа нэгэн ялгааны хазайлтыг туршилтын талбайд жил бүр ялгаатай байдлыг шалгах тестэд оруулна.

Тоон шинж чанаруудын хувьд сортуудын ялгаатай байдлыг статистикийн хэрэглээний арга нь 1 хувьтай эрсдлийн хүчин зүйлтэй тодорхойлогдсон бол ялгаатай гэж үзнэ.

Тоон аргуудын хувьд ихэвчлэн үнэлгээнд суурилан тодорхойлогдоно. Эргэлзээтэй тохиолдолд ялгаатай байдлыг тодорхойлох цорын ганц арга нь хэмжилтийн арга байна.

Өмнөх хэсэгт дурдсанчлан сортын тодорхой ялгааг тогтоохдоо ижил сорттой харьцуулах замаар тодорхойлно. Хоёр сортын хоорондын ялгаатай байдлыг тогтоох явцад илэрч буй /ажиглагдаж, хэмжигдсэн/ аливаа ялгааг яаралтай бүртгэж хөтөлнө.

Ялгаатай байдал тогтмол байна гэдгийг 3 ургалтын улирлын 2 улиралд нь эсвэл 2 дараалан ижил утга гарсан байдлыг хэлнэ.

Өмнөх хэсэгт дурдсанчлан тогтмол байдлыг хангахын тулд хэд хэдэн харьцуулсан туршилтаар ялгаатай байдал илэрхийлэгдэнэ. Харьцуулалтын тоо нь шинж чанарын хэмжилтэнд хүрч болох статистик найдвартай байдлыг хангах ёстой.

Хоёр сортын хоорондын ялгаа өөр өөрөөр үнэлэгдсэн хэд хэдэн шинж чанар дээр ажиглагдаж болох бөгөөд эдгээр шинж чанаруудын өгөгдлийг хослуулан ялгаатай байдлыг тодорхойлно. Энэ тохиолдолд харьцуулах найдвартай түвшинг энэ журмын туссаны дагуу хангана.

Вегетатив буюу өөрөө тоос хүртдэг ургамлын сортын хувьд дээжинд агуулагдах өөр ургамлын байж болох хамгийн бага хэмжээг доорх хүснэгтэд харуулав.

Дээж авах ургамлын тоо	Дээжид агуулагдах өөр ургамлын байх хамгийн их хэмжээ
<5	0
6-35	1
36-82	2
83-137	3

Дээжний хэмжээ тухайн ургамлын сортын хувьд ялгаатай, туршилтын удирдамжид туссан байна.

Ихэнх өөрөө тоос хүртдэг ургамлын хувьд дээжинд агуулагдах өөр ургамлын байж болох хамгийн бага хэмжээ дээрх хүснэгтэд дурдсанаас 2 дахин нэмэгдэнэ.

Өөрөө тоос хүртдэг ургамлын сортын хувьд стандарт болон ижил төстэй сортуудад тодорхойлсон хазайлтын хязгаарын хүрээнд хазайлтыг зөвшөөрнө.

Хэмжсэн шинж чанаруудын хувьд өөрөө тоос хүртдэг ургамлын сортуудыг хэрэв тэдгээрийн хувьсах чанар нь стандарт болон ижил төстэй сортуудын ижил шинж чанаруудын дундаж хувьсагчаас 1.6 дахин их байвал сортыг жигд бус гэж үзнэ.

Үнэлэгдсэн шинж чанарыг хэмжигдсэн шинж чанаруудтай ижил аргаар харьцуулах ёстой. Статистикийн хувьд ижил сортын бусад ургамлуудаас ялгаатай ургамлын тоо нь стандарт болон ижил төстэй сортуудын ийм ургамлын тооноос 5% -ийн эрсдэлтэй хэтрэхгүй байж болно.

Энгийн эрлийз сорт энэ журмын ..-д заасан өөрөө тоос хүртдэг ургамлын сорт гэж үзнэ. Бусад эрлийзийн төрлийн сортын хувьд ургамлын төрөл зүйл, үржүүлгийн аргаас шалтгаална. Тухайн төрлийн эрлийзийн зөвшөөрөгдсөн хазайлт нь ялгаатай, жигдэрсэн, тогтворжсон болохыг тогтоох сорилтын техникийн зааварт хэвлэгдсэн ургамлын төрөл зүйл, үржүүлгийн аргаас хамаарна.

Тодорхой бус ургамлын хэсгийг эцэг эхийн ургамлыг тусад нь тодорхойлно.

Сортын тогтворжсон байдлыг хадгалагдсан дээжийн хувьд эхний жилийн сорилтын үр дүн, дараа жил тариалахад сортын шинж чанар өөрчлөгдөхгүй байхыг хэлнэ. Сортын тогтвортой байдал сортын ялгаатай болон жигдэрсэн байдлаас бага.

Үржүүлгийн материал болон үрийн дараагийн үеийг давтан тариалах замаар сортын тогтвортой байдлыг тодорхойлно.

Хүрээлэн албан ёсны сэтгүүлд тухайн ургамлын төрлийн ялгаатай, жигдэрсэн, тогтворсон болохыг тогтоосон техникийн баримт бичгийг хэвлэн нийтлэх бөгөөд тухайн зүйл, төрөл зүйлийн хамгаалалтыг анхны мэдүүлгийн дараа 30 хоногийн дотор хэвлэн нийтэлнэ.

Ялгаатай, жигдэрсэн, тогтворсон болохыг тогтоох сорилтын техникийн зааварыг нийтлэх хүртэл ерөнхий болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн техникийн үзүүлэлтийг хэрэглэнэ.

УРЬДЧИЛСАН ТАЙЛАНГИЙН ЗАГВАР

1. Тайланг ирүүлсэн байгууллагын бүртгэлийн дугаар
2. Шалгах үйл явцыг захиалсан хүн
3. Захиалсан хүний бүртгэлийн дугаар
4. Сорт бүтээгчийн сортын тодорхойлолт
5. Шалгах үйл явцыг захиалсан хүний тухайн улсад хүсэлт гаргасан огноо
6. Хүсэлт гаргагч /нэр, хаяг/
7. Эрх бүхий этгээд эсвэл итгэмжлэгдсэн төлөөлөгч / нэр, хаяг/
8. Ургамлын латин нэр уг сортод хамааралтай
9. Ургамлын нийтлэг нэр уг сортод хамааралтай
10. Сортын нэр
11. Сортын бүтээгч /нэр, хаяг/
12. Шалгах үйл явцын гүйцэтгэгч/ шалгагч
13. Шалгасан газар болон байршил
14. Шалгасан хугацаа
15. Өмнөх тайлангийн огноо, газар
16. Ерөнхий мэдээлэл
 - 16.1. Сортын үрийн болон үржүүлгийн материалыг ирүүлээгүй
 - 16.2. Үр болон үржүүлгийн материал шаардлага хангаагүй
 - 16.3. Туршилт амжилтгүй болсон

Ажиглалт

17. Үр дүн
 - 17.1. Тайлбартай
 - 17.2. Тайлбаргүй
18. Эцсийн тайлангийн огноо
19. Тэмдэглэл: Дунд шатны тайлан төгсгөлийн тайланд нөлөөлөхгүй болно.
20. Гарын үсэг

ТАЙЛАНГИЙН ЗАГВАР

1. Тайланг ирүүлсэн байгууллагын бүртгэлийн дугаар
2. Шалгах үйл явцыг захиалсан хүн
3. Захиалсан хүний бүртгэлийн дугаар
4. Сорт бүтээгчийн сортын тодорхойлолт
5. Шалгах үйл явцыг захиалсан хүний тухайн улсад хүсэлт гаргасан огноо
6. Хүсэлт гаргагч /нэр, хаяг/
7. Эрх бүхий этгээд эсвэл итгэмжлэгдсэн төлөөлөгч / нэр, хаяг/
8. Ургамлын латин нэр уг сортод хамааралтай
9. Ургамлын нийтлэг нэр уг сортод хамааралтай
10. Сортын нэр
11. Сортын бүтээгч /нэр, хаяг/
12. Шалгах үйл явцын гүйцэтгэгч/ шалгагч
13. Шалгасан газар болон байршил
14. Шалгасан хугацаа
15. Өмнөх тайлангийн огноо, газар
16. Шалгалтын үр дүн
- 16.1. Ялгаатай байдлын тайлан

Сорт нь бусад сортоос:

- илэрхий ялгаатай
- илэрхий ялгаагүй

16.2. Жигдэрсэн байдлын тайлан

Сорт нь үржүүлгийн болон нөхөн үржүүлгийн онцлогоороо:

- жигдэрсэн байна.
- жигдрээгүй байна.

16.3. Тогтворжсон байдлын тайлан

Сорт нь үндсэн шинж чанараараа:

- жигдэрсэн байна.
- жигдрээгүй байна.

Хэрвээ шалгалтын үр дүн эерэг гарсан бол сортын тодорхойлолтыг тайланд хавсаргана.

17. Тайлбар

18. Гарын үсэг

Шинэ сортын ялгаатай, жигдэрсэн, тогтворжсныг тогтоох үйл ажиллагаа нь дараах дараалалтай явагдана.

1. Шинэ сортын бүтээгчийн эрхийн хүсэлт гаргасан сортын шинж чанаруудыг тодорхойлох

2. Хяналтын сортуудыг /хүсэлт гаргасан сорттой морфологи, физиологийн шинж чанараараа ижил төстэй сортууд болон жишээ сорт/ цуглуулах

3. Хээрийн туршилт явуулах

4. Сортын шинж чанаруудыг ажиглах

5. Ялгаатай, жигдэрсэн, тогтворжсныг үнэлэх